



2002 оны 161-р захирамжаар бүтээгдсэн

МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ


1997 оны 7 дугаар
сарын 3 өдөр

Дугаар А/121

Улаанбаатар
хот

Түлш, модон материалын зах ажиллуулах тухай

1. Худалдаа үйлчилгээний "Нар-Мон" ХХКомпаний хүсэлт, Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны саналыг үндэслэн Баянзүрх дүүргийн 14 дүгээр хорооны нутагт түлш, модон материалын зах нээн ажиллуулахыг зөвшөөрсүгэй.
2. Нийслэл хотод түлш, модон материалын захын ажиллах журмыг хэвсралтаар баталсугай.
3. Тус захын үйл ажиллагаанд байнга хяналт тавьж, дэг журам зохион байгуулалт, ариун цэврийн шаардлага хангуулж ажиллуулахыг Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар (н.Амарсанаа), Хотын цагдаагийн газар (н.Жамъянсэнгээ), "Нар-Мон" ХХКомпани (н.Хүрэлсүх) нарт даалгасугай.
4. Зөвшөөрөгдөөгүй цэгт гар дээрээс мод, нүүрсний худалдаа хийж хотын байгаль орчин, зам талбайг бохирдуулж байгаа явдлыг таслан зогсоох арга хэмжээ авахыг дүүргүүдийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛАНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Ж.НАРАНЦАЦРАЛТ

ТҮЛШ, МОДОН МАТЕРИАЛЫН ЗАХЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Нийслэлд түлш, модон материал худалдаалах төрөлжсөн, зах байгуулж ажиллуулах, хотын гудамж талбайд, мод, түлээ, нүүрсийг зөвшөөрөгдөөгүй газар эмх замбараагүй зарж байгаа явдлыг журамлах, түлш, модон материал нийлүүлэгчид, худалдаалагчид, хэрэглэгч тээвэрлэгчдийн харилцаа холбоог ойртуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Түлш, модон материалын зах нь аж ахуйн нэгж, хувь хүмүүсээс улсын чанар стандартын нөхцөл хангасан түлш, модон материал худалдаалах худалдаа, үйлчилгээний зохион байгуулалттай төрөлжсөн цэг мөн.

1.3. Түлш, модон материалын захыг нийслэлийн засаг даргын захирамжаар зөвшөөрөгдсөн газарт ажиллуулна.

1.4. Түлш гэдэгт мод, түлээ, нүүрсийг хамруулан ойлгоно.

1.5. Цаашид энэ төрлийн ажил үйлчилгээ явуулах аж ахуйн нэгж нь тухайн дүүргийн засаг даргын тамгын газар бусад холбогдох мэргэжлийн байгууллагын санал дүгнэлтийг авч НЗД-ын Зөвлөлийн хурлаар оруулан шийдвэр гарсан хойно үйл ажиллагаа явуулах эрхтэй болно.

Хоёр. Захын удирдлагын үүрэг

2.1. Худалдаа эрхлэгчдэд зуучлах, талбай, ажлын байр түрээслүүлэн борлуулалт хийлгэх; худалдаа хийх боломж олгох буюу нэмэгдэл үйлчилгээ үзүүлнэ.

2.2. Худалдаа үйлчилгээний нэр төрлөөс хамаарч лангуу, талбайг төрөлжүүлнэ.

2.3. Үйлчилгээний соёл, ариун цэвэр бараа худалдаалах арга ажиллагаа болон нийгмийн хэв журам сахиулах, авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зохицуулах талаар мэргэжлийн алба, цагдаагийн байгууллагатай хамтран ажиллана.

2.4. Худалдаа эрхлэгчдэд гэрээ хэлцлийн дагуу захын талбайд ажиллах эрхийн бичиг зураг бүхий энгэрийн тэмдэг олгоно.

2.5. Захад ариутгал цэвэрлэгээг мэргэжлийн байгууллагын зөвлөмж, графикийг баримтлан тогтмол хийж байна.

2.6. Нийслэлийн гудамж талбайд мод, түлээ, нүүрсийг зөвшөөрөгдөөгүй газар эмх замбараагүй зарж байгаа явдлыг таслан зогсоохтой холбогдсон зохион байгуулалтын арга хэмжээ авах.

2.7. Ганц бие, өндөр настан, өрх толгойлсон эмэгтэйчүүд, нэн ядуу амьдралтай хүмүүсийг мод, түлээ, нүүрсээр хангах ажлыг дүүргүүдийн халамжийн төвүүдтэй хамтран зохион байгуулах.

Гурав. Худалдаа эрхлэгчийн үүрэг

3.1. Иргэд аж ахуйн нэгж нь захтай байгуулсан гэрээний дагуу хураамж төлж баримт авснаар худалдаа эрхлэх эрхтэй болно.

3.2. Худалдаа эрхлэгч нь борлуулж буй бүтээгдэхүүнийхээ чанарыг хариуцана.

3.3. Захын удирдлагуудын хууль ёсны шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.

Дөрөв. Худалдаа эрхлэгчдэд хориглох зүйл

- 4.1. Ажлын цагийн хуваарь зөрчих
- 4.2. Зөвшөөрөгдсөнөөс өөр бусад худалдаа үйлчилгээ хийх
- 4.3. Худалдаахйх эрхийн бичиг, тэмдгийг бусдад шилжүүлэх
- 4.4. Захын талбайд архи уух, тамхи татах нийгмийн хэв журам зөрчих
- 4.5. Зөвшөөрөгдөөгүй газраас мод, бургас тайрч, хөрөөдөх худалдах.

Тав. Хяналт шалгалт, хариуцлага

5.1. Захын үйл ажиллагааг орон нутгийн засаг захиргаа, төрийн хууль хяналтын байгууллага, тэдгээрийн албан тушаалтан, улсын байцаагч нар эрхийн дагуу шалгана.

5.2. Зах нь зохих шаардлага хангаагүй нөхцөлд түр буюу бүрмөсөн хаах асуудлыг төр, олон нийтийн хяналтын байгууллага, эрх бүхий албан тушаалтан, улсын байцаагч нар шийдвэрлэж орон нутгийн засаг захиргаа, татварын албанд мэдэгдэнэ.